

Үзэл бодлоо илэрхийлэх онлайн ба офлайн эрх чөлөөний талаарх ЕХ-ны хүний эрхийн удирдамж

ГАДААД ХЭРГИЙН ЗӨВЛӨЛИЙН хурал

Брюссель, 2014 оны 5-р сарын 12

Хавсралт 1

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг зөрчиж болзошгүй бодлого, үйл ажиллагааны жишээ

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө хэрэгжүүлсний төлөө хувь хүнд халдах: Үзэл бодлоо илэрхийлсний төлөө цаазаар авах, сэтгүүлчид болон бусад хүмүүсийн амийг хороох, хүчээр алга болгох, эрүүдэн шүүх, дур мэдэн баривчлах зэрэг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийг зөрчиж буй хэрэг мөн.

Хуулийн хязгаарлалт: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах аливаа зохицуулалтыг хуулиар тогтоосон байх, зөвхөн олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр тодорхойлсон үндэслэлд нийцсэн, зайлшгүй шаардлагатай бөгөөд зохистой байх шалгуурыг хангасан байх ёстой.

Хууль тогтоомжийн уялдаа холбоогүй, урвуулан ашигласнаар шүүмжлэл, олон нийтийн хэлэлцүүлгийг цагдан хянаж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн дунд айдас, өөрийн цензурын уур амьсгалыг бий болгох эрсдэлтэй. Сэтгүүл зүйн үйл ажиллагааг дур мэдэн зохицуулах, сэтгүүлчдээс лиценз буюу тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэл шаардах, үгүйсгэх, мэдээлэл авах эрхийг хязгаарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслийг үүсгэн байгуулахтай холбоотой хууль эрх зүйн саад бэрхшээл учруулах зэрэг нь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүхэлд нь болон хэсэгчлэн, урьдчилан цагдах, хориглох үйл ажиллагааны жишээ мөн. Түүнчлэн хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө бүхий татвар, хураамж ногдуулах болон эдийн засгийн бусад хэлбэрийн хэлбэрээр үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах арга хэлбэр байна.

Интернэтийн орчинд ихэвчлэн зарим тодорхой вэбсайтыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хориглохыг хуулиар зөвшөөрөх аргаар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарладаг. Зарим улс орны онцгой нөхцөлд Интернэтийн сүлжээг бүрэн салгаж, улмаар бүхэл бүтэн улс эсвэл бүс нутгийг дэлхийн бусад хэсгээс тусгаарлах тохиолдол байна. Мэдээллийн хэрэгслийн төрлөөс үл хамаарч мэдээллийн хүртээмж, чөлөөт урсгалыг үндэслэлгүйгээр хязгаарлахгүй байх хуулийн баталгааг бий болгох нь чухал юм.

Гүтгэлгийн тухай хууль: Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан, зохиолч, уран бүтээлч, улс төрийн идэвхтэн болон бусад хүний эрхийг хамгаалагчдыг дэлхий даяар гүтгэлгийн хэргээр шоронд хорьсоор байна. Гүтгэлгийн тухай хуулиар эрүүгийн болон иргэний хатуу шийтгэл хүлээхээс айх, болгоомжлох үүднээс өөрийгөө хянах хандлага нийгэмд түгэн дэлгэрдэг. Европын Холбооны зүгээс олон нийтийн асуудалтай холбоотой шүүмжлэл, хэлэлцүүлгийг цагдан хянах зорилгоор гүтгэлийн тухай хуулийн заалтыг ашиглах ёсгүй хэмээн үзэж байна.

Нийтийн ёс суртахуун, үндэсний аюулгүй байдал, "үндэсний үнэт зүйлсийг" хамгаалах зорилгыг урвуулан ашиглах: Олон улсын хүний эрхийн хуулиар зөвхөн

шашин шүтлэг, соёл, үзэл суртал, улс төрийн суртал ухуулга зэргийг хамгаалах үүднээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахыг зөвшөөрдөггүй. Зарим улсад олон нийтийн ёс суртахууныг хамгаалах нэрийдлээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах үйл ажиллагааг зохион байгуулж байна. Жишээлбэл, ялгаварлан гадуурхах шашны үзэл баримтлалыг олон нийтийн дунд ил тодоор шүүмжилдэг эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах бүлгүүдийг айлган сүрдүүлэх, дарамтлах үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудын аль алиных зүгээс зохион байгуулсаар ирсэн.

Үндэсний аюулгүй байдал: Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах нэрээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хор хөнөөл учруулах, хязгаарлах тохиолдол түгээмэл байна. Зарим улс орон терроризмын эсрэг хууль, эх орноосоо урвах тухай хууль эсвэл үндэсний аюулгүй байдалтай холбоотой ижил төстэй заалтуудыг (төрийн нууцын тухай хууль, үймээн самуунтай тэмцэх тухай хууль гэх мэт) олон улсын хүний эрхийн хуулийн хүрээнд хүлээсэн үүргийнхээ дагуу боловсруулж, хэрэгжүүлэхэд анхаарах ёстой.

Бурхныг гутаан доромжлохоос хамгаалах хууль: Бурхныг доромжлохыг гэмт хэрэг гэж тооцдог хуулиуд нь шашны болон бусад итгэл үнэмшилтэй холбоотой үг, үзэл санааг хязгаарладаг. Эдгээрийг шашны болон бусад цөөнхөд харьяалагддаг хүмүүсийг хавчиж, зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэх зорилгоор ихэвчлэн ашиглах нь түгээмэл бөгөөд энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, шашин шүтэх, итгэл үнэмшлийн эрх чөлөөнд ноцтой саад учруулдаг. Европын Холбоо ийм төрлийн үйлдлийг гэмт хэрэг гэж үзэхгүй байхыг зөвлөж, бурхныг доромжилсон хэргээр цаазаар авах, бие махбодын шийтгэл, эрх чөлөөг нь хасах ялыг хэрэглэхгүй байхыг хүчтэй дэмжиж байна. Европын Холбоо Бурханыг доромжлохоос хамгаалах тухай хуулийг цуцлахыг дэмжигч байгууллагуудтай хамтран ажиллаж, тэднийг дэмжих болно.

"Үзэн ядсан үг хэллэг" (Hate speech) : Олон улсын эрх зүйд "үзэн ядсан үг хэллэг" гэх нэр томъёоны нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байдаггүй. Энэ ойлголтыг ихэвчлэн гутаан доромжилсон, айлган сүрдүүлсэн, дарамталсан, эсвэл тодорхой шинж чанар бүхий хувь хүн, бүлгүүдийн эсрэг хүчирхийлэл, үзэн ядалт, ялгаварлан гадуурхалтыг өдөөх илэрхийлэлд ашигладаг. Олон улсын эрх зүйн хүрээнд улс орнууд ялгаварлан гадуурхах, дайсагналцах, хүчирхийллийг өдөөн турхирах, үндэстэн, арьс өнгө, шашны үзэн ядалтыг сурталчлах зэрэг үзэн ядалтын үг хэллэгийн хамгийн хатуу хэлбэрийг хориглох үүрэгтэй (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20.2-р зүйл, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг устгах тухай конвенц 4-р зүйл). Төрөөс үзэн ядсан үг хэллэгийн тухай хууль тогтоомжийг нийтийн ашиг сонирхлын асуудлаар хууль ёсны ардчилсан хэлэлцүүлэгт саад учруулах зорилгоор урвуулан ашиглаж болохгүй.

Европын нөхцөлд Хүний эрхийн тухай Европын конвенцид нэг талаас хэт даврагч үзлийг бодитой бөгөөд ноцтойгоор өөгшүүлэх, нөгөө талаас хувь хүмүүсийн (сэтгүүлч, улс төрчдийг оролцуулан) үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх буюу "гомдоох, цочирдуулах, үймүүлэх" эрхийг ялгаж салгадаг. Хүний эрхийн тухай Европын конвенцийн хүрээнд арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн зарим хэлбэр, илэрхийлэлтэй эрүүгийн хуулиар тэмцэх тухай Европын Холбооны суурь шийдвэрт гишүүн орнууд дараах зөвлөмжийг хүргэсэн байдаг. Үүнд хүчирхийлэл, үзэн ядалтыг олон нийтийн дунд зориудаар өдөөн турхирсан, түүнчлэн олон улсын зарим гэмт хэргийг хүлээн зөвшөөрөх, үгүйсгэх, гэм зэмгүй мэт болгож харагдуулах замаар хүчирхийлэл, үзэн ядалтыг санаатайгаар өдөөн турхирсныг гэмт хэрэг хэмээн үзэж шийтгэх.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, олон ургалч үзлийг хязгаарлах: Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, олон ургалч үзлийг хязгаарлах нь мэдээлэл хүлээн авах, түгээх эрх чөлөөнд халдаж, улмаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх олон нийтийн итгэлийг сулруулж, ардчиллыг хэрэгжүүлэхэд саад учруулж болзошгүй юм. Түүнчлэн, хэвлэл мэдээллийн эрх чөлөө сул байх нь сэтгүүл зүйн “хоточ нохойн” үүрэг, эрх баригчдаас хариуцлага шаардах чадварыг бууруулдаг. Түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө төрийн болон хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бие даасан байдлыг хангах санхүүжилтийн бүтэцтэй нягт холбоотой гэдгийг анхаарах хэрэгтэй. Шударга, хараат бус хэвлэл мэдээллийн зах зээл нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Хэвлэлийн эрх чөлөөний эрх зүйн зохицуулалтыг тодорхой сонирхолд нийцүүлж, хэвлэл мэдээллийн нөхцөлд байдалд нөлөөлөх зорилгоор ашиглаж болохгүй.

Зохицуулах байгууллагуудын хараат бус байдал: Зохицуулах байгууллагууд төрийн нөлөөллөөс хараат бус байх нь чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл хөгжихийн амин чухал нөхцөл юм. Зохицуулах байгууллагын бүх гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох үйл явцыг журамлахдаа тэдний бие даасан байдал, хараат бус байдлыг хамгаалах баталгаажуулсан байх ёстой. Үндэсний зохицуулах байгууллагууд нь улс төрийн шууд хөндлөнгийн оролцооноос ангид байх ёстой бөгөөд хүний эрх, тэр дундаа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах эерэг үүрэг гүйцэтгэх ёстой.

Интернэтийн хязгаарлалт: Маш хязгаарлагдмал нөхцөл байдлаас бусад тохиолдолд (жишээ нь шүүхийн шийдвэр, хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэх, тухайлбал, Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх, сүлжээний аюулгүй байдлын чухал асуудлууд, хүсээгүй харилцаанаас урьдчилан сэргийлэх, онцгой нөхцөл байдалтай холбоотой сүлжээний ачааллыг багасгах гэх мэт) тодорхой агуулга, программ, үйлчилгээг хэзээ ч хааж, удаашруулж, доройтуулж, ялгаварлан гадуурхаж болохгүй. Мөн янз бүрийн хууль тогтоомжийг зүй бусаар ашигласан, ялгаварлан гадуурхсан (хувьсах геометр), хувийн Интернэтэд суурилсан платформ эсвэл программын зүй бус ашиглалтыг хөндлөнгөөс хязгаарлаж болно. Wifi-ийг саатуулах нь хувь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах цензурын бас нэгэн арга хэрэгсэл мөн.

Мэдээлэл олж авах эрхийг хязгаарлах: НҮБ-ын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх Тусгай илтгэгч олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу олон нийтийн мэдээлэл авах эрхтэй холбоотой хууль тогтоомжийг батлахыг парламентуудад зөвлөж, бүх ардчилсан нийгэмд төр, засгийн ажиллагааны ил тод байдлын ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн.

Оюуны өмчийн эрхийг хамгаалах үүднээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах: Зохиогчийн эрхийг хамгаалах үндэслэлээр вэб сайт руу нэвтрэхийг хориглох нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэтрүүлэн хязгаарлах эрсдэлийг дагуулдаг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний аливаа хязгаарлалт нь энэхүү удирдамжийг 20-р зүйлд заасан гурван шалгуурыг хангах ёстой.

Хувийн нууц, хувийг мэдээллийг хамгаалах эрхийг хязгаарлах: Хувийн харилцаа холбоог хууль бусаар хянах, түүнийг таслан зогсоох, түүнчлэн хувийн мэдээллийг хууль бусаар цуглуулах нь хувийн нууцыг хадгалах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг зөрчих, хязгаарлах эрсдэлтэй.

Хувь хүний хувийн нууцад зүй бусаар хөндлөнгөөс халдах нь үзэл бодлоо чөлөөтэй хөгжүүлэх, солилцох боломжийг шууд болон шууд бусаар хязгаарлаж болзошгүй юм. Жишээлбэл, нэрээ нууцлах эрхийг хязгаарлах нь хүчирхийллийн бүх хэлбэрийн хохирогчид давхар хүчирхийлэлд өртөхөөс эмээж, хүчирхийллийн талаар мэдээлэхээс зайлсхийх байдалд хүргэдэг.

Үүнтэй холбогдуулан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17-р зүйлд захидал харилцаанд хөндлөнгөөс халдахаас хамгаалах тухай шууд дурдсан бөгөөд энэ нэр томъёог онлайн болон офлайн харилцаа холбооны бүх хэлбэрт хамаатуулан ашиглах ёстой.

Хувийн мэдээлэлд төрийн болон хувийн компани хууль бусаар, эсвэл дур зоргоороо ашиглах нь иргэдийн цахим харилцааны технологийг ашиглалтад сөргөөр нөлөөлөх магадлалтай учир үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах эрсдэлийг дагуулдаг.